



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/170

Хэрлэн сум

Волейболын Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гар бөмбөгийн 2023 оны идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 3 дугаар сарын 26-ний өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл Чингис хотод зохион байгуулсугай.

2. Идэрчүүдийн 2023 оны улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах салбар хороог доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар хорооны дарга:	Д.Өнөрцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Салбар хорооны Нарийн бичиг:	З.Энхболд	Монголын Волейболын холбооны Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга
Гишүүд:	Н.Зоригтбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	С.Оюун-эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Г.Болд	Монголын Волейболын холбооны Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн Тэргүүлэгч
	О.Ган-Очир	Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн ахмад

· 231010459

2.

Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
С.Мөнхцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Д.Оюунгэрэл	Нэгдсэн эмнэлгийн дарга
Д.Цогт-Эрдэнэ	Хан хэнтий чуулгын дарга
Л.Наранбат	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Г.Солонго	Биеийн тамир, спортын газрын Албаны дарга
Б.Болд-Эрдэнэ	Политехникийн коллежийн сургалтын менежер

3.Тэмцээнийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж хяналт тавьж ажиллахыг Салбар хорооны дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ